



Япон хэлний “Хитонен” клубийн танилцуулга

Япон хэлний “Хитонен” клуб нь оюутнуудын санаачлагаар 2017 оны 3-р сарын 14-ний өдөр байгуулагдсан. ШУТИС-ийн нийт оюутнуудыг хамарсан үйл ажиллагаа явуулдаг.

“Хитонен” клуб нь япон хэл, соёлыг түгээн дэлгэрүүлэх, сонирхогч оюутан залуус болон япон хэлний хичээл сонгон суралцаж байгаа оюутнуудыг дэмжиж идэвхжүүлэх, хичээлд нь туслах, илүү хялбараар хөгжих, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөхөд нь туслах зорилготой сайн дурын клуб юм.

Клубийн үйл ажиллагааны чиглэл нь япон хэл, соёлын хичээл, японы уламжлалт болон орчин үеийн соёл урлаг, дуу хөгжим, анимэ танилцуулах, япон оюутнууд, Монголд амьдарч ажиллаж байгаа япон хүмүүстэй ярианы хичээл зохион байгуулах, япон хэлний түвшин тогтоох шалгалтад бэлтгэх зорилтот сургалт зохион байгуулах, Япон орон, хэл соёлтой холбоотой үйл ажиллагаа, арга хэмжээний танилцуулга мэдээлэл хийх, оюутан залуусыг хамруулах зэрэг болно.

2022-2023 оны хичээлийн жилд клубын зөвлөх багшаар япон хэлний багш Т.Солонго, клубийн ахлагчаар “Техник технологийн орчуулга /Япон хэл/” мэргэжлийн 2-р курсийн оюутан Т.Дөлгөөн нар ажиллаж байна.



Хичээлийн шинэ жилийн нээлтийн арга хэмжээний үеэр клубын танилцуулга /2018.09.01/



Хичээлийн шинэ жилийн нээлтийн арга хэмжээний үеэр клубийн танилцуулга /2022.09.01/



Японд суралцах мэдээллийн яармагт хамрагдав /2018.04/



ШУТИС-ийн клубуудын нэгдсэн арга хэмжээний үеэр /2018.03/



Түвшин тогтоох шалгалтын зорилтот хичээлийн үеэр /2018.04/



Багшийн цаг дээр /2018.04//Тухайн үеийн зөвлөх багш Б.Ундармаа/



Япон оюутнуудтай ярианы хичээлийн үеэр /2022.05.16/



Япон оюутнуудтай ярианы хичээлийн үеэр /2022.05.16/



Япон оюутнуудтай ярианы хичээлийн дараа /2022.05.16/



Япон оюутнуудтай ярианы хичээлийн үеэр /2022.09.21/



Япон оюутнуудтай ярианы хичээлийн дараа /2022.09.21/



Японы соёлыг танилцуулах хичээлийн үеэр /2022.10/



Японы соёлыг танилцуулах хичээлийн дараа /2022.10/



Японы соёлыг танилцуулах хичээлийн
үеэр /2022.10/



Японы соёлыг танилцуулах хичээлийн үеэр
/2022.10/